



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АЙМГИЙН 2021–2025 ОНЫ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ
ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ, САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ
ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ОЛГООГҮЙ БАЙНА.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ЗАА-2026/05-12/ШТА-НА



Улиастай хот

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Мөнхнасан
Утас: 90066888, Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

Аудитор Н.Цогтсайхан
Утас: 99125745, Цахим хаяг: tsogtsaikhann@audit.gov.mn

Аудитор О.Алтансувд
Утас: 92050909, Цахим хаяг: altansuvd.oyu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг www.open.audit.mn хаягаас үзнэ үү

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товъёг.....	2
Зураглалын товъёг	3
Тушаал	4

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл ... 5-6

БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 28.4 ХУВИЙГ АЙМГИЙН 2021-2025 ОНЫ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА. 6-12

- 1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн боловч, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд үндэслэн төлөвлөөгүй байна.
- 1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад төлөвлөлтийн шаардлага хангаагүй зарим төсөл, арга хэмжээг баталсан байна.

БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА..... 12-21

- 2.1 Нийт зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 80.3 хувь нь хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.
- 2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

БҮЛЭГ ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 64 ТӨСӨЛ БУЮУ 86.5 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН БАЙНА..... 21-32

- 3.1 Хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй, мөн зарим тохиолдолд санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.
- 3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгагдаагүй, мөн өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

ДҮГНЭЛТ..... 33-34

ЗӨВЛӨМЖ:..... 35-36

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ..... 37-40

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР..... 41-48

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХБТХО	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
НТШЗ	Нээлттэй тендер шалгаруулах зааварчилгаа
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Зураг төсөвгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ	11
2	Зураг төсөв ор хийгдээгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ	11
3	Хуулийн хугацаанд зохион байгуулаагүй ХАА-ны тоо	16
4	Шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ХАА-ны тоо, хувь	16
5	Хууль, журамд нийцүүлэн үнэлээгүй үндэслэл, ТАХ-ний тоо	17
6	Сангийн яаманд гаргасан гомдлын тоо	20
7	Захиалагч болон зохиогчийн хяналт хийсэн судалгаа	23
8	Төсөл арга хэмжээ санхүүжилт (сая төгрөг	26
9	Автомашинь техникийн тодорхойлолтын харьцуулалт	29
10	Дизель хөдөлгүүрийн техникийн тодорхойлолтын харьцуулалт	29

ЗУРАГЛАЛЫН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Хөрөнгө оруулалтын төрөл	7
2	ТАХ-ний Гүйцэтгэл хувь	22
3	ГХБХБГ-ын техник хяналтын зардлын задаргаа	26



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/15

Улиастай

"Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2025 оны А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор шилжүүлэх эрх"-ийн 9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, нийслэл дэх Төрийн аудитын газар, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нар болон холбогдох бусад газруудад хүргүүлэхийг шинжээч (У.Хорлоо)-д нээлттэй аудит цахим хуудсаар нийтэд мэдээлэхийг аудитор (Г.Нармандах)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Жалбаа)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

D:\Албан бичиг\Тушаал-А-2026.docx

8126010029

**Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн
талаарх мэдэгдэл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэсэн.

**Аудитын
зорилт**

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;

Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрж, бүртгэлд тусгасан эсэх;

**Аудитын
хамарсан
хүрээ**

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан аймгийн Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нар, тэдгээрийн харьяа байгууллагууд, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудитыг хийж гүйцэтгэсэн.

**Аудитын
хязгаарлалт**

Аудитад орон нутгийн төсвөөс 2025 онд хийгдэх авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтыг хамруулаагүй болно.

**Аудитын
арга зүй,
шалгуур
үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
багийн**

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер

**бүрэлдэхүүн,
хугацаа**

Х.Болдбаатар нар хянан удирдаж, аудитор Б.Мөнхнасан, Н.Цогтсайхан, О.Алтансүвд нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлүүлж, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2026 оны 3 дугаар сарын 09-өөс 4 дүгээр сарын 17-ны хооронд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2025 оны 4 дүгээр сарын 20-ний өдрөөс эхлүүлж, тайланг 2025 оны 5 дугаар сарын 11-ний өдөр газрын дарга, тэргүүлэх аудитораар баталгаажуулан Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга, бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 22 дугаар тогтоолоор 2025 онд Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтад 13,815.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 төсөл арга хэмжээг баталсан бөгөөд 2025 оны 08 дугаар сарын 23-ний өдрийн 47 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж хөрөнгө оруулалтын жагсаалтад өөрчлөлт оруулан баталсан байна. Уг тогтоолд барилга байгууламжийн шинж чанартай 2,678.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15, их засвар, тохижилтын 2,531.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16, тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, тавилга, автомашин худалдан авахад 3,788.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бусад 127.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, нийт 9,125.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 74 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс 1,767.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжин хэрэгжиж байна.

Мөн төсөл арга хэмжээний 3,260.4 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээг сумдад болон байгууллагад эрх шилжүүлсэн байна.

БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 28.4 ХУВИЙГ АЙМГИЙН 2021-2025 ОНЫ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн боловч, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд үндэслэн төлөвлөөгүй байна.

Аймгийн Засаг даргын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2024 оны 15 дугаар тогтоолоор, мөн аймгийг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор тус тус баталж, Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан байна.


Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7,008.6 сая төгрөгийн өртөг бүхий 62 төсөл, арга хэмжээ, мөн тухайн

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

жилд хэрэгжүүлэх их засварын 2,117.0 сая төгрөгийн өртөгтэй 12 төсөл, арга хэмжээ нийт 74 тоог хянах төсөл, арга хэмжээг 9,125.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Нийт төсөл, арга хэмжээний 14 хувийг боловсрол, 8 хувийг эрүүл мэнд, 9 хувийг соёл, 15 хувийг нутгийн өөрөө удирдах байгууллага, 15 хувийг тусгай чиг үүргийн байгууллага, 39 хувийг бусад салбарт тус тус хуваарилан төлөвлөсөн байна. Үүнийг графикаар харуулбал:

Дүрслэл №1. Хөрөнгө оруулалтын төрөл



Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Дээрх төсөл, арга хэмжээг аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг шалгахад 2,565.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээ Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй уялдаагүй, байгаа нь нийт төлөвлөсөн төсөл арга хэмжээний 28.4 хувийг эзэлж байна. Үүнд:

- ✓ Сантмаргаз суманд дугуйт "Эксковатор" авах 180.0 сая төгрөг,
- ✓ Тэс суманд "Ковш-50" авах 180.0 сая төгрөг,
- ✓ Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйлчилгээний автомашин авах 265.0 сая төгрөг,
- ✓ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны өрөөнүүдийг засварлах 100.0 сая төгрөг,
- ✓ Хилийн цэргийн 0277 дугаар ангийн албан хаагчдын орон сууцны барилгыг барих 300.0 сая төгрөг,
- ✓ Улиастай сумын ХТҮА-нд "Автогрейдер" авах 250.0 сая төгрөг,
- ✓ Улиастай сумын ХТҮА-нд замын "Индүү" авах 100.0 сая төгрөг,
- ✓ Цагаанхайрхан суманд "Ковш-50" авах 57.0 сая төгрөг,
- ✓ Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх 20.0 сая төгрөг,
- ✓ Их-Уул суманд өөрөө буулгагч хогны машин авах 260.0 сая төгрөг,
- ✓ Шилүүстэй суманд өөрөө буулгагч хогны машин авах 130.0 сая төгрөг,
- ✓ Төрийн албаны салбар зөвлөлд компьютер тоног төхөөрөмж авах 70.0 сая төгрөг,
- ✓ Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг тоног төхөөрөмжөөр хангах 115.5 сая төгрөг,

- ✓ Аймгийн Засаг даргын Тамгын газрын "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг сургалтын төв болгох 150.0 сая төгрөг,
- ✓ Их-Уул сумын Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж авах 50.0 сая төгрөг,
- ✓ Аймгийн Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж авах 44.0 сая төгрөг,
- ✓ Сум дундын Прокурорын газарт тоног төхөөрөмж авах 15.0 сая төгрөг,
- ✓ Аймгийн Прокурорын газарт тоног төхөөрөмж авах 19.5 сая төгрөг,
- ✓ Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газарт автомашин авах 160.0 сая төгрөг,
- ✓ Гамшгийн эрсдэлийг даван туулах ажлын хүрээнд иргэдэд гэр олгох 80.0 сая төгрөг,
- ✓ Тосонцэнгэл сумын хүүхэд хамгааллын төвд засвар хийх 19.0 сая төгрөг,

Энэ нь аймгийн хүрээнд боловсруулсан бодлогын баримт бичгийн уялдаа хангалтгүй байгааг харуулж байна.

Дээрх төлөвлөлт нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.17¹, 6 дугаар зүйлийн 6.9², 6.10.3³, 6.10.4⁴ дахь заалтуудын шаардлагыг хангаагүй бөгөөд улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан төсөв, төлөвлөлтийг боловсруулах шаардлагуудтай нийцэхгүй байна.

Бодлогын баримт бичгүүдийн уялдаа хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, аймгийн хөгжлийн төлөвлөлт алдагдах, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгдэх эрсдэлийг бий болгож байна.

Иймд хөрөнгө оруулалтын хүрээнд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

Өмнөх аудитаар уг зөрчилтэй холбоотой зөвлөмж өгсөн боловч зөрчил давтан гарсаар байна. Энэ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн нөлөөлөл их байгаатай холбоотой байна гэж үзлээ. Учир нь өөр өөрсдийн тойрог, сумандаа төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтуудыг баталж байна.

¹ Төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим

² Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна

³ Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх

⁴ Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх

Цаашид бодлогын баримт бичгийг боловсруулахдаа дээрх шаардлагуудыг бүрэн хангаж, төлөвлөлтийн чанар, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээнүүдийг олон нийтийн саналд үндэслэн эрэмбэлсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд:

- ✓ Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь сумд, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудаас хөрөнгө оруулалтын санал, төслүүдийг хүлээн авч байгаа хэдий ч тэдгээрийг нэгдсэн, нэг аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлээгүй байна. Өөрөөр хэлбэл, төслийн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх үндэслэл, мөн тухайн төслөөс гарах үр дүн, нийгэм-эдийн засгийн өгөөжийг цогцоор нь харьцуулан шинжлэх, үнэлэх нарийвчилсан судалгаа, дүгнэлт хангалттай хийгддэггүй байна. Үүний улмаас төслүүдийн ач холбогдлыг бодитой эрэмбэлэх, үр ашигтай хөрөнгө оруулалтыг сонгох боломж хязгаарлагдаж байна.
- ✓ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн санал, төсөл, арга хэмжээг хэлэлцэн батлахдаа иргэдийн бодит санал, хэрэгцээ шаардлагыг хангалттай хэмжээнд тусган авч үзээгүй байна. Зарим үед тухайн орон нутгийн нийт хөгжлийн бодлого, урт болон дунд хугацааны зорилт, нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан шийдвэр гаргахын оронд өөрийн сонгогдсон тойрогт чиглэсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг түлхүү дэмжихийг урьтал болгох хандлага ажиглагдаж байна. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын тэгш бус хуваарилалтыг бий болгох, зарим сум, багийн хөгжлийн хэрэгцээг орхигдуулах, улмаар аймгийн хэмжээнд хөгжлийн тэнцвэргүй байдал үүсэх эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн төсвийн төлөвлөлт, зарцуулалт нь бодит судалгаа, хэрэгцээ шаардлагад суурилах зарчим алдагдах, олон нийтийн оролцоо, итгэлцэл буурах сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах журам”-ын 2.1.3⁵, 2.2.1⁶, 2.2.2⁷ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд орон нутгийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан судалгааг жил бүр тогтмол хийж, аймгийн богино болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан ирээдүйд үр өгөөжөө өгөх, орон нутгийн хөгжилд бодит дэмжлэг үзүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлон төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

⁵ Төсөл, арга хэмжээг холбогдох журам, аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгах санал боловсруулах;

⁶ Төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэн, эрэмбэлэх, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тогтоох;

⁷ Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох жагсаалт гаргах

Ингэхдээ бага өртөгтэй, урсгал зардалд хамаарах боломжтой зардлыг хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээс зайлсхийж, тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагад тулгуурлан эрэмбэлсэн, тооцоо судалгаанд үндэслэсэн төсөл, арга хэмжээг төлөвлөхөд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүд нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхэд ажиглалт хийхэд дараах төсөл арга хэмжээнүүдийг нэн тэргүүний асуудал гэх үндэслэлгүй байна. Үүнд:

- ✓ *Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг тоног төхөөрөмжөөр хангах,*
- ✓ *Цагаанхайрхан сумын ЭМТ-д нөхөн сэргээх физик эмчилгээ, оношилгооны төв байгуулах,*
- ✓ *Аймгийн 24 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах,*
- ✓ *Яруу суманд газар тариалангийн усалгааны систем авах,*
- ✓ *Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг дэмжиж тоног төхөөрөмж авах,*
- ✓ *Эрдэнэхайрхан суманд газар тариалангийн усалгааны систем авах,*
- ✓ *Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйлчилгээний автомашин авах,*
- ✓ *Сум дундын Прокурорын газарт тоног төхөөрөмж авах,*
- ✓ *Аймгийн Прокурорын газарт тоног төхөөрөмж авах,*
- ✓ *Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газарт автомашин авах,*
- ✓ *Идэр сумын ЕБС-ийн гадна хайс, тохижилт хийх зэрэг байна.*

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлалгүй, нэн тэргүүний ач холбогдолтой асуудлыг тодорхойлж төлөвлөөгүй нь хөрөнгө оруулалтын үр ашиг буурах, төсвийн хязгаарлагдмал нөөц үр дүнгүй зарцуулагдах, нийгэм, эдийн засгийн хамгийн тулгамдсан асуудлууд шийдэгдэхгүй хоцрох, иргэдийн амьдралын чанарт бодит сайжралт гарахгүй байх, төрийн бодлого, төлөвлөлтөд итгэх итгэл сулрах, хөгжлийн бодлогын уялдаа алдагдах зэрэг олон талын сөрөг үр дагавар үүсэж байна.

Цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө бодит хэрэгцээ, шаардлагад суурилсан судалгаа, шинжилгээг сайжруулж, нэн тэргүүний ач холбогдол бүхий төслүүдийг тодорхой шалгуур, эрэмбэ тогтоон сонгох, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаа холбоог бүрэн хангах замаар хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад төлөвлөлтийн шаардлага хангаагүй зарим төсөл, арга хэмжээг баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан, 2025 онд шинээр хэрэгжих 64 төсөл, арга хэмжээний 9 нь барилга байгууламжийн шинж чанартай, 1 нь зөвлөх үйлчилгээ, 12 нь их засвар, тохижилт, 42 нь тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, тавилга, автомашин худалдан авах төсөл, арга хэмжээ байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд дараах нөхцөл байдалтай байна.

- ✓ Техник, эдийн засгийн үндэслэл болон батлагдсан зураг төсөв шаардлагатай 3,300.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээ байна. Үүний 2,627.7 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээний зураг төсөв хийгдээгүй байхад хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан бөгөөд 2,331.7 сая төгрөгийн 9

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

төсөл арга хэмжээний зураг төсвийг төсөв батлагдсаны дараа хийлгэсэн байна.

Хүснэгт №1. Зураг төсөвгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ

Төсөл арга хэмжээний нэр	Төсөв (сая төгрөг)	Зураг төсөв хийгдсэн огноо	Аймгийн төсөв батлагдсан огноо	Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалттай нийцсэн эсэх
Улиастай сумын Өлзийт багт 160 айлын орон сууц, хаус хорооллын инженерийн шугам сүлжээ барих, ЦДШ татах. /Төсөвт өртөг 493.8 сая төгрөг 2025 онд 98.7 сая төгрөг 2026 онд 395.1 сая төгрөг санхүүжинэ/	98.7	2025 он	2024.12.20	Нийцээгүй
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны өрөөнүүдийг засварлах	100.0	2025.01 сар	2024.12.20	Нийцээгүй
Аймгийн Засаг даргын Тамгын газрын "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг сургалтын төв болгох	150.0	2025.04 сар	2024.12.20	Нийцээгүй
Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	450.0	2025.04 сар	2024.12.20	Нийцээгүй
Нөмрөг сумын спорт заалыг засварлах	168.0	2025.01 сар	2024.12.20	
Аймгийн Цагдаагийн газрын гаржийн дээврийг засварлах	90.0	2025.04 сар	2024.12.20	Нийцээгүй
Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн спорт зааланд агч модон шал шинээр хийх	95.0	2025.04 сар	2024.12.20	Нийцээгүй
Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгад засвар хийх	980.0	2025.01 сар	2024.12.20	Нийцээгүй
Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах	200.0	2025.03 сар	2024.12.20	Нийцээгүй
Нийт	2,331.7			

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Зураг төсөв ор хийгдээгүй 296.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ.

Хүснэгт №2. Зураг төсөв ор хийгдээгүй төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ

Төсөл арга хэмжээний нэр	Төсөв (сая төгрөг)	Зураг төсөв хийгдсэн огноо	Аймгийн төсөв батлагдсан огноо	Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалттай нийцсэн эсэх
Алдархаан сумын Чигэстэй багт Иргэдийн хөгжлийн төв барих	87.0	Зураг төсөвгүй	2024.12.20	Нийцээгүй
Цагаанчулуут сумын цэцэрлэгийн барилгад засвар хийх	30.0	Зураг төсөвгүй	2024.12.20	Нийцээгүй
Цагаанчулуут сумын сургуулийн барилгад засвар хийх	50.0	Зураг төсөвгүй	2024.12.20	Нийцээгүй
Тосонцэнгэл сумын хүүхэд хамгааллын төвд засвар хийх	19.0	Зураг төсөвгүй	2024.12.20	Нийцээгүй
Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих	110.0	Зураг төсөвгүй	2024.12.20	Нийцээгүй
Нийт	296.0			

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээнүүдээс ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 2,627.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг ИТХ-аар

баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁸, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5⁹ дахь заалтыг зөрчсөн байна.

- ✓ Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй МУ-ын гавьяат багш Б.Энхбаярын Байгалийн ухааны цогц хичээл буюу "Сургалтын хөдөлгөөнт үзүүлэн бэлтгэх төсөл"-ийг ерөнхий боловсролын сургуулиудад нэвтрүүлэх зардалд 50.0 сая төгрөг төлөвлөж баталсан байна.

Төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан нь бодит хэрэгцээнд нийцээгүй хөрөнгө оруулалт хийгдэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хэрэгжүүлсэн төслүүдийн нийгэм, эдийн засгийн үр нөлөө сул байх, давхардсан болон ач холбогдол багатай төсөл хэрэгжих зэрэг сөрөг үр дагавар, эрсдэл үүсгэж байна.

Цаашид хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлагыг чанд мөрдөж, бодит хэрэгцээ, судалгаа, үр ашгийн тооцоонд тулгуурласан үндэслэлтэй шийдвэр гаргалтыг хангах, мөн төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах болон эрэмбэлэх үйл ажиллагааг сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Иймд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа төсөвлөлтийн шаардлага хангасан арга хэмжээг баталж байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

- ✓ Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан машин техник, тоног төхөөрөмжийн өртгийг бодитой төлөвлөсөн эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд машин техник, тоног төхөөрөмжийн өртгийг төлөвлөхдөө зах зээлийн өнөөгийн үнэ ханш, нийлүүлэлтийн бодит нөхцөл байдал, тээвэрлэлтийн болон суурилуулалтын зардал зэрэг холбогдох бүх хүчин зүйлийг харгалзан үзсэн, бодит зах зээлийн дундаж түвшинтэй уялдсан байна.

Тухайн тоног төхөөрөмжүүдийн үнийн санал, ижил төстэй бүтээгдэхүүний харьцуулсан судалгаа, нийлүүлэгч байгууллагуудын албан ёсны үнийн мэдээлэлд үндэслэн тооцоолол хийсэн бөгөөд төсөвлөсөн дүн нь хэрэгжүүлэх үеийн бодит худалдан авалтын зардалтай нийцэх боломжтой гэж үзэж байна.

БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1 Нийт зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 80.3 хувь нь хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх

⁸ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁹ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөө, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

74 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан боловч ХАА-г зохион байгуулж эхлэх хугацааг 2025.03.06-ны өдрөөс эхлүүлсэн, зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах хугацааг оройтож /2025.05.23/ төлөвлөж байгаа нь тус төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд амжиж дуусахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 27 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Төсвийн тухай хуулийн 14, 61 дүгээр зүйлийг үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 21, 3 дугаар сарын 17-ны өдрүүдэд шилжүүлсэн нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1¹⁰ дэх заалттай нийцээгүй, 1 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлэх шийдвэрт тусгалгүйгээр төсөв захирагч нарт шилжүүлсэн байна.

Эрх шилжсэн зарим төсөл арга хэмжээний үнэлгээний хороог төсөв захирагч нар цаг хугацааны хувьд оройтож байгуулснаас тухайн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа хуульд заасан хугацаанд амжихгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ. Тухайлбал:

- Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах ажлын үнэлгээний хороог 2025.04.29-ний өдөр
- Их-Уул сумын Засаг даргын Тамгын газарт тоног төхөөрөмж авах ажлын үнэлгээний хороог 2025.05.01-ний өдөр тус тус байгуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 46 дугаар тогтоолоор хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нэмж тусгагдсан төсөл, арга хэмжээ болох Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газарт автомашин авах, Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих 2 төсөл, арга хэмжээний үнэлгээний хороог Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж буюу 2025.09.03-ны өдөр байгуулсан байна.

Төрийн албаны салбар зөвлөлд компьютер тоног төхөөрөмж авах ажлын хүсэлтийг 2025.01.29-нд, Аймгийн 24 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүсэлтийг 2025.01.31-нд, Шилүүстэй суманд өөрөө буулгагч хогны машин авах ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулж өгөх тухай хүсэлтийг 2025.02.14-ний өдөр аймгийн ХААГ-т хүргүүлсэн боловч тус ажлуудын үнэлгээний хороог хүсэлт ирүүлснээс 19-35 хоногийн дараа байгуулжээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар 24 төсөл, арга хэмжээний үнэлгээний хороог 2025.03.06-ны өдөр байгуулсан боловч захиалагч байгууллагуудаас худалдан авах ажиллагаа зохион байгуулж өгөх тухай хүсэлтийг үнэлгээний хороо байгуулагдсанаас 6-110 хоногийн дараа аймгийн ХААГ-т хүргүүлсэн байна.

Энэ нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталснаас зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, баталгаажуулахад тодорхой цаг хугацааг зарцуулсантай холбоотой байна.

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг судлан үзэхэд өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаагүй, зөрчлийг давтан гаргаж үнэлгээний хороог

¹⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна

төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай бүр байгуулаагүй, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг хараат бус гишүүнээр томилон ажиллуулсан байна.

Иймд тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний ХАА-г зохион байгуулах хугацааг эрт төлөвлөх, хуульд заасан хугацаанд эрх шилжүүлэх, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хүсэлтийн хамт аймгийн ХААГ-т цаг хугацааны хувьд эрт хүргүүлж байх, үнэлгээний хороог тухай бүрд буюу хүсэлт ирсэн даруйд байгуулан ажиллаж байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа худалдан авах тоног төхөөрөмжийн үнийн урьдчилсан судалгаа хийгээгүй, техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг нарийвчлан боловсруулаагүйгээс нийлүүлсэн бараа чанарын шаардлага хангахгүй байх, ижил үзүүлэлт бүхий барааг харилцан адилгүй үнээр худалдан авах зэрэг үр дагавар үүсэж байна. Тухайлбал:

- Тэс, Шилүүстэй, Цэцэн-Уул сумдын Соёлын төвд лед дэлгэц авах 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ижил үзүүлэлт бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх ажлуудад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн аж ахуйн нэгжүүд нь дээрх тоног төхөөрөмжийг 39.5, 48.0, 34.1 сая төгрөгөөр гэрээ байгуулсан нь тус тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтод үнийн урьдчилсан судалгаа хийгээгүй, мөн дээрх тендер шалгаруулалт бүрд гомдол гарсан нь техникийн тодорхойлолтод тавигдах шаардлагыг нарийвчлан боловсруулаагүй байсантай холбоотой байна гэж дүгнэж болохоор байна.
- Шилүүстэй болон Их-Уул сумдад өөрөө буулгагчтай хогны автомашин худалдан авах төсөв 130.0 сая төгрөг атлаа захиалагчаас техникийн тодорхойлолтыг өөр өөрөөр боловсруулж хүргүүлсэн.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх автомашин худалдан авах ТББ-ын техникийн тодорхойлолтод автомашины орж ирсэн оныг "... 2024 оны сүүл" гэж тодорхой заагаагүй нь оролцогчдод ойлгомжгүй байдлыг үүсгэсэн байна.

Сумдад эрх шилжүүлсэн 7 төсөл арга хэмжээний ТББ-т тухайн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах шаардлагыг тусгаагүй байна. Тухайлбал:

- Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах, Дөрвөлжин сумын ундны усны эх үүсвэрт ус цэвэршүүлэгч суурилуулах, Сантмаргаз суманд дугуйт Эксковатор авах ажлуудын ТББ-т ямар тусгай зөвшөөрөл шаардахаа тодорхой тусгаагүй;
- Цагаанчулуут сумын сургуулийн барилгад засвар хийх, Цагаанхайрхан сумын ЭМТ-д нөхөн сэргээх физик эмчилгээ, оношилгооны төв байгуулах ажлуудад барилгын холбогдох тусгай зөвшөөрөл шаардах байсан боловч шаардаагүй;
- Завханмандал суманд хүнсний ногоо тариалахад шаардагдах иж бүрэн тоног төхөөрөмж, трактор авах техникийн тодорхойлолтыг тодорхой бус оновчтой боловсруулаагүйгээс тендерийг үнэлэхэд хүндрэл учирсан;

- Цагаанхайрхан сумын ЭМТ-д нөхөн сэргээх физик эмчилгээ, оношилгооны төв байгуулах ажлын ТББ-т санхүүгийн чадавх техникийн болон туршлагын шаардлагыг огт тусгаагүй;
- Их-Уул сумын ЗДТГ-т тоног төхөөрөмж авах, Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах ажлуудын ТББ-т санхүүгийн, техникийн чадавх болон туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлт зэргийг тодорхой тусгаагүй байна.

Иймд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах санхүү, техникийн болон туршлагын шаардлагыг тендерийн баримт бичигт тодорхой тусгах, техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа үнийн урьдчилсан судалгаа хийж байх албан шаардлагыг аймаг, сумын Засаг дарга нар, ХААГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөөнд 64 төсөл арга хэмжээ тусгагдсанаас 12 төсөл арга хэмжээг шууд худалдан авах гэрээ байгуулж, 51 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг харьцуулалтын арга болон нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулан ажилласан байна.

Онцгой байдлын газарт эрх шилжүүлсэн “Гамшгийн эрсдэлийг даван туулах ажлын хүрээнд иргэдэд гэр олгох” 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг гэрээ шууд байгуулан худалдан авсан бөгөөд ингэхдээ аймгийн Онцгой комиссын 2025.04.30-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлд үндэслэн хялбаршуулан журмаар худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2¹¹ -т заасантай нийцэхгүй байна.

ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан хугацаа, үнэлгээний хороог оройтож байгуулсан, захиалагчаас хүсэлтийг оройтож хүргүүлсэн зэргээс шалтгаалан 22 ТАХ-г худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанаас хоцроон зарлаж нийт зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 31.3%-ийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1¹²-т заасан хугацаанд зохион байгуулж дуусгаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчлийг давтан гаргасан байна.

Худалдан авах ажиллагааг хугацаа алдаж зохион байгуулснаар тухайн ТАХ-г хугацаанд нь хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах, он дамжин үргэлжлэх, өртөг нэмэгдэх зэрэг эрсдэлийг дагуулж байна.

Хүснэгт №3 Хуулийн хугацаанд зохион байгуулаагүй ХАА-ны тоо

№	ХАА зохион байгуулсан байгууллага	Зохион байгуулсан ХАА-ны тоо	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хугацаанд зохион байгуулаагүй ХАА-ны тоо
---	-----------------------------------	------------------------------	--

¹¹35.1.2.онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;

¹² Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1	Худалдан авах ажиллагааны газар	27	10
2	Сумд	17	6
3	Байгууллага	7	0
	Нийт	51	16

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Аймгийн ХАА-ны газар нь 2025 оны ХАА-ны төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 4,126.0 сая төгрөгийн 27, сумын Засаг дарга нар 2,717.0 сая төгрөгийн 17, төсвийн шууд захирагч нар 543.4 сая төгрөгийн 7, нийт 51 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулжээ.

Үүнээс Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих ажлын тендер шалгаруулалтыг 2025.09.04-ний өдрөөс эхлэн 4 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй, амжилтгүй болсон байна.

Хилийн цэргийн 0277 дугаар ангид эрх шилжүүлсэн албан хаагчдын орон сууцны барилга барих 300.0 сая, Зэвсэгт хүчний 325-р ангид эрх шилжүүлсэн аймгийн 5 бүст шуурхай бүлгийн хөдөлгөөнт удирдлагын байртай болох 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнүүд нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн үйлчлэлд хамаарахгүй харилцаа бөгөөд дээрх байгууллагууд энэхүү төсөл, арга хэмжээний худалдан авалтыг өөрийн байгууллагаас мөрдөж буй журмын хүрээнд зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороод 5,979.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41 /нийт зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 80.3% / төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.4.2¹³, 26.9¹⁴, 27 дугаар зүйлийн 27.5¹⁵ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Хүснэгт №4 Шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ХАА-ны тоо, хувь

№	ХАА зохион байгуулсан байгууллага	Зохион байгуулсан ХАА-ны тоо	Шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ХАА-ны тоо	Хувь
1	Худалдан авах ажиллагааны газар	27	24	88.8
2	Сумд	17	13	76.4
3	Байгууллага	7	4	57.1
	Нийт	51	41	80.3

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Үнэлгээний хороод тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэхдээ ТБОНӨХБАҮХАТХуулийн 16 дугаар зүйл Санхүүгийн чадавхын шаардлага, 17 дугаар зүйл Техникийн чадавх болон туршлагын шаардлага хангаагүй оролцогчийг сонгон шалгаруулж байгаа нь нийт зөрчлийн 68.1%-ийг эзэлж байна.

Хүснэгт №5 Хууль, журамд нийцүүлэн үнэлээгүй үндэслэл, ТАХ-ний тоо

¹³ санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх;

¹⁴ Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

¹⁵ Тендерийг энэ хуулийн 11.4.1-д зааснаар үнэлэхэд харьцуулах үнийг, энэ хуулийн 11.4.2-т зааснаар үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу тооцсон үнийг тус тус өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.

№	Хууль, журамд нийцээгүй үндэслэл	Төсөл, арга хэмжээний тоо /давхардсан/
1	Оролцогчийн ерөнхий шаардлагыг хангаагүй	2
2	Хуулийн 16 дугаар зүйл, ТББ-т тусгасан санхүүгийн чадавхын шаардлага хангаагүй	18
3	Хуулийн 17 дугаар зүйл, ТББ-т тусгасан техникийн чадавх, туршлагын шаардлага хангаагүй	27
4	Тендерийн баримт бичигт шаардсан тусгай зөвшөөрөлгүй	5
5	Төсөв, нийлүүлэлтийн хуваарь, тоо хэмжээ зөрүүтэй	11
6	ТББ-т шаардаагүй шалгуураар үнэлсэн	3
	ДҮН	66

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны өрөөнүүдийг засварлах ажлын тендерт шалгарсан “Азмөнх жаргал” ХХК нь тендер нээсэн өдрөөр нийгмийн даатгалын шимтгэлд 982,080 төгрөгийн өртэй, Алдархаан сумын Чигэстэй багт Иргэдийн хөгжлийн төв барих тендерт шалгарсан “Манант оргил” ХХК нь шүүхийн шийдвэрийн тодорхойлолт ирүүлээгүй, туслан гүйцэтгэгч болох “Өгөөмөр баян булаг” ХХК-ийн ерөнхий шаардлага хангах материалыг ирүүлээгүй байхад ерөнхий шаардлагыг хангасан гэж үнэлжээ.

Үнэлгээний хорооноос тендерт оролцогчийн санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт болох “Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээний дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн эрх нээсэн гэрээ ирүүлэх” гэсэн шалгуур үзүүлэлтийг тендерийн баримт бичигт тусган шаардаж байгаа боловч тендерт оролцогчдын ирүүлж буй харилцагч банкны тодорхойлолтууд нь тендерт оролцоход, тендерт шалгарсан тохиолдолд болон банкны журмын дагуу шаардлага хангасан нөхцөлд зээлийн санхүүжилт олгох боломжтой гэх зэрэг тодорхойлолтууд ирүүлж байгааг шаардлага хангасан гэж үнэлж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5¹⁶, Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын 6.2¹⁷ дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг тендерийн баримт бичгүүдэд тодорхой тусгасан боловч тендерийг хянан үзэж үнэлэхдээ тус шалгуур үзүүлэлт, шаардлагад нийцэх, тоо хэмжээ бүрэн эсэхийг бүрэн гүйцэд хянаагүйгээс тухайн ажлын чанар болон нийлүүлэгдэх бараа, тоног төхөөрөмж нь чанарын шаардлага хангахгүй байх, тоо хэмжээ дутуу нийлүүлэгдэх эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал:

¹⁶Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна.

¹⁷ Харилцагч банкны мэдэгдэл нь зээл олгох асуудлыг судлан үзэх боломжтой гэх мэт банканд бодитой санхүүгийн үүрэг хүлээлгээгүй бол түүнийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

- Улиастай сумын Чигэстэй багт гэрэлтүүлэг хийх ажлын тоо хэмжээний гэрэлтүүлэгчийн ажил 9.Төмөр бетон суурь шугамын трассын дагуу ачиж буулгах ажлын хэмжих нэгжийг /тонн/ м3 гэж зөрүүтэй ирүүлсэн.
- Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйлчилгээний автомашин авах багц 2-т захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан загвар G-full option -ийг стандарт опшин гэж ирүүлсэн.
- Улиастай сумын 2-р цэцэрлэгт тоног төхөөрөмж авах ажлын барааны тоо хэмжээний аяга ариутгагч 4 -ийг 1 гэж үнийн саналд ирүүлсэн.
- Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газарт автомашин авах ажилд Топ моторс ХХК нь Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан Тоноглол хэсгээс хөгжим, шалавч, халаалтын систем хойд, өвлийн 5 ширхэг дугуйг орхигдуулсан.
- Тэс сумын соёлын төвд "ЛЕД" дэлгэц авах Амжилтын нар ХХК: Техникийн тодорхойлолтын оролтын төрөл:-SDL, YD-SDI etc -гүй тоног төхөөрөмж нийлүүлэхээр ирүүлсэн.
- Улиастай сумын ХТҮА-нд Автогрейдер авах Мөнгөн цаст очирваань ХХК Нийлүүлэхээр санал болгож буй барааны техник үзүүлэлтийг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлээгүй.
- Улиастай сумын ХТҮА-нд замын индүү авах Мөнгөн цаст очирваань ХХК техникийн тодорхойлолтын доргиурын давтамж 30/36 герц-ийг орхигдуулсан, Техникийн хэмжээ: өргөн 3200-г 2200 гэж зөрүүтэй бага ирүүлсэн.
- Тэс суманд хөдөө аж ахуй, газар тариалангийн Трактор, тоног төхөөрөмж авах Эм ти эм жи ХХК нь хаман боогчийн техникийн тодорхойлолтод заасан шаардагдах хүч 90 морины хүчээс дээшийг 80+ м.х гэж дутуу ирүүлсэн.
- Цагаанхайрхан суманд "Ковш-50" авах Оттомир ХХК нь захиалагчийн техникийн тодорхойлолтын ухаж өргөх хүч, даац, түлшний төрлийг зөрүүтэй ирүүлсэн байна.

Тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл шаардсан боловч үнэлгээний хороод тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй дараах аж ахуйн нэгжүүдийг хамгийн сайн тендер ирүүлсэн гэж үнэлжээ. Үүнд:

- Аймгийн Цагдаагийн газрын гаржийн дээврийг засварлах ажилд шалгарсан “Дэлгэрэх төгс хийц” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;
- Улиастай сумын Өлзийт багт 160 айлын орон сууц, хаус хорооллын инженерийн шугам сүлжээ барих, цахилгаан дамжуулах шугам татах ажилд шалгарсан “Таван тайхар” ХХК нь ТББ-т шаардсан БХБЯ-ны 3.2. Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажлын тусгай зөвшөөрөлгүй
- Алдархаан сумын Чигэстэй багт Иргэдийн хөгжлийн төв барих ажилд шалгарсан “Манант оргил” ХХК нь ТББ-т шаардсан БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралтын тусгай зөвшөөрөлгүй

- Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах “И эс би ай” ХХК-ийн БУ37/356/19 дугаартай тусгай зөвшөөрөл нь 2024.03.15-ны өдөр дууссан бөгөөд тус баримт бичигт Тусгай зөвшөөрлийн сунгалт нь БХБ-ын сайдын 2024.04.08-ны өдрийн тушаалаар батлагдсан гэж худал мэдээлэл ирүүлсэн.
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгад засвар хийх ажилд шалгарсан үндсэн оролцогч “Жавхлант тур” ХХК нь ТББ-т шаардсан БА-4.1.Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэт болон иж бүрэн цутгамал бүтээцэт барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил, гадна фасад тусгай зөвшөөрөлгүй, түншлэлээр оролцогч “Байгаль алтай” ХХК нь тусгай зөвшөөрөлтэй ба түншлэлийн гишүүн тус бүр хангасан байх шаардлагыг хангаагүй байна.

Аудитаар зарим сумдын үнэлгээний хороод худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг боловсруулсан, дахин зарласан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг журмын дагуу бүрэн гүйцэд хөтлөөгүй, эсвэл тендерийн үнэлгээний хороо хуралдаагүй, мөн зарим тэмдэглэлд хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, үнэлгээний хорооны зарим гишүүд уг хуралд оролцсон эсэх нь эргэлзээтэй, тендерийг хянан үзэхдээ маягтын дагуу үнэлээгүй, холбогдох журам заавар, аргачлалыг баримтлаагүй зэрэг нийтлэг зөрчил илэрлээ.

Иймд цаашид Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах санхүү, техникийн болон туршлагын шаардлагыг тендерийн баримт бичигт тодорхой тусгах, үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулах болон тендерийг хянаж, үнэлэхдээ бүх гишүүдийн оролцоог хангах, үнэлгээг маягтын дагуу хийх, хурлын тэмдэглэлийг журмын дагуу бүрэн гүйцэд үнэн зөв хөтлөх зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгад засвар хийх, Улиастай сумын Өлзийт багт 160 айлын орон сууц, хаус хорооллын инженерийн шугам сүлжээ барих, цахилгаан дамжуулах шугам татах ажлуудад шалгарсан аж ахуйн нэгжүүдийн түншлэлийн мэдээллийг үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмж болон ажил гүйцэтгэх гэрээнүүдэд тусгаагүй зөрчил илэрсэн бөгөөд түншлэл, туслан гүйцэтгэгчийн мэдээллийг дүгнэлт, зөвлөмж, гэрээнд бүрэн тусгаж байх зөвлөмжийг аймгийн ХААГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

Үнэлгээний хороод ТБОНӨХБАҮХАТХ, тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар болон үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журмыг зөрчиж, ТББ-т шаардаагүй шалгуураар үнэлсэн зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Эрдэнэхайрхан суманд газар тариалангийн усалгааны систем авах ажилд ТБОНӨХБАҮХАТХуулийн 34.10.Энэ хуулийн 34.9-д зааснаар хянан үзэхэд тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ гэж заасан бөгөөд “Аржма мөнх” ХХК-ийг шаардлагад нийцээгүй гэж үзэн удаах оролцогч “Би Би Кэй Эйч” ХХК болон “Ньюкомпасс” ХХК-иудын ирүүлсэн тендерийг хянан үзсэний дараа “Аржма мөнх” ХХК-ийг шалгаруулсан
- Шилүүстэй сумын соёлын төвд лед дэлгэц авах тендер шалгаруулалтад оролцсон 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн чадавхыг /түргэн хөрвөх хөрөнгө/ үнэлэхдээ ТББ-т заагаагүй шалгуураар /1-2 тендерт шалгарсан тул / шаардлага хангаагүй гэж үнэлсэн.

- Завханмандал суманд хүнсний ногоо тариалахад шаардагдах иж бүрэн тоног төхөөрөмж, трактор авах ҮХ-ны гишүүд тендерийг үнэлэхдээ ХХК-иудыг санхүүгийн тайланд өртэй гэж үнэлсэн

ТБОНӨХБАҮХАТХ, тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар болон үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журмыг зөрчиж, ТББ-т шаардаагүй шалгуураар үнэлсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлагыг аймгийн ХААГ болон Завханмандал сумын Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ХАА-тай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр 11 гомдлыг гаргаж, Сангийн яамнаас дээрх гомдлыг хянан үзэж захиалагчийн гаргасан 8 шийдвэрийг үндэслэлтэй байна гэж шийдвэрлэжээ.

Хүснэгт №6 Сангийн яаманд гаргасан гомдлын тоо

№	ХАА зохион байгуулсан байгууллага	Гарсан гомдлын тоо	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй шийдвэрийн тоо
1	Худалдан авах ажиллагааны газар	9	8
2	Сумд	1	0
3	Байгууллага	1	0
Нийт		11	8

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Сангийн яам оролцогч 3 компанийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэн холбогдох шийдвэрийг захиалагчид хүргүүлсэн боловч Тэс суманд хөдөө аж ахуй, газар тариалангийн трактор, тоног төхөөрөмж авах ажлын үнэлгээний хороо хууль, журамд нийцсэн шийдвэр гаргасан бол дараах 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод Сангийн яамнаас гаргасан шийдвэрийн хүрээнд зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Үүнд:

- Аймгийн ХААГ-аас зохион байгуулсан Их-Уул сумын Соёлын төвд тоног төхөөрөмж, лед дэлгэц авах тендер шалгаруулалтад гаргасан гомдолд Сангийн яамны 2025.04.21-ний өдрийн 02/3127 дугаар шийдвэрээр захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгож хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг даалгасан боловч үнэлгээний хороо дахин хянан үзэж, үнэлэхдээ хууль тогтоомж зөрчиж шаардлага хангаагүй аж ахуйн нэгжийг дахин шалгаруулсан;
- Аймгийн ИТХ-аас зохион байгуулсан Төлөөлөгчдийг тоног төхөөрөмжөөр хангах тендер шалгаруулалтад гаргасан гомдолд Сангийн яамны шийдвэрээр захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгож хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг даалгасан байхад үнэлгээний хороо дахин хянан үзэхдээ тус компанийг хуурамч гэрээ ирүүлсэн гэж дүгнэсэн боловч ТБОНӨХБАҮХАТХуулийн 48 дугаар

зүйлийн 48.2.10¹⁸-д заасан захиалагчийн үүргээ хангалтгүй хэрэгжүүлжээ.

ХАА-тай холбоотой алдаа зөрчлүүд арилахгүй, давтагдан гарахад :

- Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, аргачлал, зааврыг дагаж мөрдөх үүргээ биелүүлдэггүй,
- ТББ-т шаардсан шаардлагыг хэрхэн үнэлэх, аргачлал, зааврын талаарх ойлголт үнэлгээний хорооны гишүүдэд дутмаг,
- Тус үнэлгээний хороодын гаргаж буй шийдвэрүүдэд тавих захиалагчийн хяналт байхгүй зэрэг нөлөөлж байна.

Иймд цаашид тендерийн баримт бичигт туссан ерөнхий, санхүүгийн, техникийн болон чадавхын шаардлагуудыг үнэлэх талаар үнэлгээний хорооны гишүүд, сумдын ХАА хариуцсан албан хаагч нарт арга, зүйн зөвлөгөө өгөх арга хэмжээг зохион байгуулж ажиллах, үнэлгээний хорооны зөвлөмж, шийдвэрүүд хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавьж ажиллахыг даалгаж аймгийн ЗДТГ, Худалдан авах ажиллагааны газарт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

"Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" сэдэвт аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

Өмнөх аудитаар аймгийн Засаг дарга болон аймгийн ХААГ-т өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг энэ удаагийн аудитаар давтан шалгахад төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үнэлгээг хийхдээ хууль, журам, тендерийн баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулахгүй байх зөрчлийг давтан гаргаж тендер сонгон шалгаруулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Иймд энэхүү алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх илэрсэн алдаа зөрчлөөс дүгнэхэд аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд нэгдсэн удирдамжаар дотоод аудит хийж хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авах зайлшгүй шаардлага үүссэн нь харагдаж байна. Иймд энэхүү арга хэмжээг зохион байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ 64 ТӨСӨЛ БУЮУ 86.5 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН БАЙНА.

3.1 Хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй, мөн зарим тохиолдолд санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

¹⁸ Энэ хуулийн 56.5-д заасан нөхцөл илэрсэн оролцогчийн талаарх мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт худалдан авах ажиллагааны улсын байцаагчид хянуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх"

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих 74 төсөл, арга хэмжээний 64 нь гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэн бөгөөд үүнээс 10 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэсэн боловч үлдсэн 54 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнээгүй байна.

Хэрэгжилт дутуу 8 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- ✓ Товцог багийн төв авто замын хоёр талаар явган хүний зам болон дугуйн зам хийх
- ✓ Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах
- ✓ Алдархаан сумын Чигэстэй багт Иргэдийн хөгжлийн төв барих
- ✓ Улиастай сумын Өлзийт багт 160 айлын орон сууц, хаус хорооллын инженерийн шугам сүлжээ барих, ЦДШ татах.
- ✓ Тэлмэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах
- ✓ Эрдэнэхайрхан суманд инженерийн шугам сүлжээг өргөтгөх
- ✓ Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах
- ✓ Улиастай сумын ЕБ-ын ЧЭС-ийн спорт заалны шалыг агч модон шалаар сольж засварлах

Төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан нь санхүүжилтийн хуваарилалт он дамжсан, шийдвэр гаргах үйл явц удааширсан болон гүйцэтгэлийн чанар хангалтгүй байгаатай шууд хамааралтай байгаа бөгөөд үүний үр дагавраар гэрээний хугацаа сунгагдаж, ажил 2026 оны II дугаар улиралд болон хичээлийн амралтын хугацаа руу шилжин хойшлогдсон нь төсвийн хөрөнгийн ашиглалт, хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулж, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг саатуулахын зэрэгцээ төлөвлөсөн үр дүнд хүрэхэд сөргөөр нөлөөлж байна.

Аудитаар нийт 8 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй бөгөөд 809.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон ч хэрэгжилт хангалтгүй, хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй нь тогтоогдсон тул холбогдох байгууллагуудад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.


Хэрэгжээгүй 2 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих,
- Ургамал сумын ерөнхий боловсролын сургуульд засвар хийх,

Дүрслэл №2 ТАХ-ний Гүйцэтгэл хувь

Дээрх 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд: Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих төслийн хувьд тендерийг 4 удаа зарласан боловч шаардлага хангасан аж ахуйн нэгж санал ирүүлээгүй тул дараа онд шилжсэн байна. Харин Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийн засварын ажлын төсөлд тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан боловч гүйцэтгэгч байгууллага ажлыг хугацаанд нь эхлүүлээгүйгээс төсөл хэрэгжээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тавигдах захиалагчийн болон техникийн



хяналтыг бүх шатанд хэрэгжүүлжсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд:

- ✓ Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2025 онд сумд болон байгууллагуудад эрх шилжээгүй хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс болон Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу захиалагчийн болон техникийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.
- ✓ Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь шинэ барилга болон барилгын их засварын ажлуудад техникийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг ГХБХБГ-тай байгуулан ажиллаж, 2025 онд хэрэгжсэн барилга, их засварын нийт 24 төсөл, арга хэмжээний 14-т нь захиалагчийн хяналтыг хийж, гүйцэтгэлийг акт болон фото зургаар баталгаажуулсан байна.
- ✓ Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгын засвар болон Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах 2 төсөл, арга хэмжээнд зураг, төсөл зохиогчтой зохиогчийн хяналтын гэрээ байгуулан хяналт хийсэн боловч бусад төсөл, арга хэмжээнүүдэд зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, улмаар хяналт хэрэгжээгүй байна.
- ✓ ГХБХБГ газар нь захиалагчийн хяналт буюу техникийн хяналтын үйл ажиллагааг жилийн нэгдсэн төлөвлөгөө, хуваарийн дагуу зохион байгуулахгүй, сар бүр тус тусад нь хуваарь гарган батлуулж хэрэгжүүлж байгаа нь хяналтын тогтолцооны тогтвортой байдал, уялдаа холбоо сул байгааг харуулж байна.

Хүснэгт №7 Захиалагч болон зохиогчийн хяналт хийсэн судалгаа

№	Төсөл арга хэмжээний нэр	Захиалагчийн хяналт хээгжүүлсэн эсэх	Зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн эсэх	Ашиглалтад орсон эсэх
1	Товцог багийн төв авто замын хоёр талаар явган хүний зам болон дугуйн зам хийх	Тийм	Үгүй	Үгүй
2	Улиастай сумын Чигэстэй багт гэрэлтүүлэг хийх	Тийм	Үгүй	Тийм
3	Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах	Үгүй	Үгүй	Үгүй
4	Алдархаан сумын Чигэстэй багт Иргэдийн хөгжлийн төв барих	Үгүй	Үгүй	Үгүй
5	Улиастай сумын Өлзийт багт 160 айлын орон сууц, хаус хорооллын инженерийн шугам сүлжээ барих, ЦДШ татах.	Тийм	Үгүй	Үгүй
6	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны өрөөнүүдийг засварлах	Тийм	Үгүй	Тийм
7	Хилийн цэргийн 0277 дугаар ангийн албан хаагчдын орон сууцны барилгыг барих	Тийм	Үгүй	Тийм
8	Улиастай сумын Богдын гол багийн ус түгээх №10, №18 дугаар байрыг цэвэр усны төв шугамд холбох	Үгүй	Үгүй	Тийм


ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

9	Эрдэнэхайрхан суманд гэрэлтүүлэг хийх	Тийм	Үгүй	Тийм
10	Эрдэнэхайрхан суманд инженерийн шугам сүлжээг өргөтгөх	Тийм	Үгүй	Үгүй
11	Яруу суманд хадлангийн талбай хаших	Үгүй	Үгүй	Тийм
12	Аймгийн Засаг даргын Тамгын газрын "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг сургалтын төв болгох	Тийм	Үгүй	Тийм
13	Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих	Үгүй	Үгүй	Хэрэгжээгүй
14	Тосонцэнгэл сумын хүүхэд хамгааллын төвд засвар хийх	Үгүй	Үгүй	Тийм
15	Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	Тийм	Тийм	Үгүй
16	Цагаанчулуут сумын цэцэрлэгийн барилгад засвар хийх	Үгүй	Үгүй	Тийм
17	Цагаанчулуут сумын сургуулийн барилгад засвар хийх	Үгүй	Үгүй	Тийм
18	Идэр сумын ЕБС-ийн гадна хайс, тохижилт хийх	Үгүй	Үгүй	Тийм
19	Нөмрөг сумын спорт заалыг засварлах	Тийм	Үгүй	Тийм
20	Цэцэн-Уул сумын цэцэрлэгийн дотор сантехникийг засварлах	Үгүй	Үгүй	Тийм
21	Аймгийн Цагдаагийн газрын гражийн дээврийг засварлах	Тийм	Үгүй	Тийм
22	Улиастай сумын ЕБ-ын ЧЭС-ийн спорт заалны шалыг агч модон шалаар сольж засварлах	Тийм	Үгүй	Үгүй
23	Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн спорт зааланд агч модон шал шинээр хийх	Тийм	Үгүй	Тийм
24	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгад засвар хийх	Тийм	Тийм	Тийм

Эх сурвалж: Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн баримтын хүрээнд

Цаашид зураг төсөл зохиогчтой зохиогчийн хяналтын гэрээг бүрэн байгуулж, хяналтын ажлыг тогтмол хэрэгжүүлэх хуваарийг урьдчилан баталж мөрдүүлэх, мөн хяналт бодитоор хийгдсэн эсэхийг баримтаар нотлон дүгнэж байж зохиогчийн хяналтын зардлыг олгодог байх шаардлагатай байна.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн эрх шилжээгүй төсөл арга хэмжээнүүдэд захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Шинээр хэрэгжиж байгаа барилга, их засварын ажлуудын бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлж барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийн дэвтэрт бичилт хийж ажилласан байна.



Харин сумдад эрх шилжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдэд тавих хяналт хангалтгүй байна. Тухайлбал: Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах, Алдархаан сумын Чигэстэй багт Иргэдийн хөгжлийн төв барих, Эрдэнэхайрхан суманд инженерийн шугам сүлжээг өргөтгөх, Ургамал сумын ерөнхий боловсролын сургуульд засвар хийх ажлуудад мэргэжлийн байгууллагын захиалагчийн болон техникийн хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс ажлын гүйцэтгэл чанарын шаардлага хангаагүй, улмаас хэрэгжилт удааширч, ажил дутуу он дамжин хийгдэх нөхцөл байдал үүсээд байна.

Сумдад эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт сул байгаа нь орон нутгийн түвшинд мэргэжлийн боловсон хүчний нөөц дутагдалтай, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх арга зүй хангалтгүй байгаатай холбоотой бөгөөд үүний улмаас барилга байгууламжийн чанар алдагдах, төсөвт өртөг үндэслэлгүй өсөх, ажил он дамжин саатах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах сөрөг үр дагаврууд үүсэж байгаа тул цаашид Барилгын тухай хуулийн дагуу захиалагчийн болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар заавал гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

Хүснэгтээс харахад төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд хяналт хийгээгүй байна. Иймд захиалагч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагад хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.


Аймгийн ЗДТГ-ын техник хяналтын зардалд 774.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 658.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үүнээс Аймгийн ЗДТГ-аар 550.9 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд томилолт, шатахууны зардалд 30.3 сая төгрөг, сэлбэг хэрэгсэлд 47.0 сая төгрөг, тоног төхөөрөмж болон ажлын хувцсанд 25.6 сая төгрөг, автомашин худалдан авахад 298.0 сая төгрөг, аудитын албан шаардлагын дагуу 150.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нийт зарцуулалтаас 215.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан бөгөөд үлдэх 335.8 сая төгрөгийг зориулалт бусаар болон баримтын бүрдүүлэлт дутуу зарцуулсан зөрчил илэрсэн байна.

Дүрслэл №3 ГХБХБГ-ын техник хяналтын зардлын задаргаа

ГХБХБГ-ын техник хяналтын зардлын 107.8 сая төгрөгийг зарцуулснаас 19.9 сая төгрөгийг автомашины засварт, 16.9 сая төгрөгийг 9 хүний ажлын хувцас, 9.5 сая төгрөгийг сургалтын зардалд, 61.5 сая төгрөгийг томилолт, шатахууны зардалд тус тус зарцуулсан байна.



Аймгийн ЗДТГ нь техник хяналтын зардлаас зориулалтын бус, баримтын бүрдүүлэлт дутуу зарцуулсан 37.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Түүнчлэн, сумдад болон байгууллагуудад эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээнд заасан нөхцөл болон бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байгаа нь төсвийн сахилга батыг алдагдуулж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 2025 онд нийт 74 төсөл, арга хэмжээнд 9,125.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас тайлант хугацаанд гүйцэтгэгч байгууллагуудад 6,782.8 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 74.3 хувийг олгосон байна.

Хүснэгт №8 Төсөл арга хэмжээ санхүүжилт (сая төгрөг)

№	Нэр	Тоо	2025 оны батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл санхүүжилт
1	Барилга байгууламж	15	2,678.3	1,566.4	1,111.9
2	Их засвар	16	2,531.4	1,731.6	799.8
3	Тоног төхөөрөмж	42	3,788.9	3,434.8	354.1
4	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ	1	127.0	50.0	77.0
Дүн		74	9,125.6	6,782.8	2,342.8

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 74 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээс дараах төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. Үүнд:

- ✓ Алдархаан сумын Чигэстэй багт иргэдийн хөгжлийн төв барих ажлын гүйцэтгэл 40 хувьтай байхад захиалагч байгууллага баталгаажуулж бодит гүйцэтгэлээс илүү буюу 70 хувиар тооцож санхүүжилтийг олгосон байна.



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- ✓ Хилийн цэргийн 0277 дугаар ангийн албан хаагчдын орон сууцны барилгын ажлын санхүүжилтийг олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй 4.9 сая төгрөгийг илүү санхүүжүүлсэн байна.



- ✓ Түдэвтэй суманд нийтийн биеийн тамирын спортын тайлбай байгуулах ажил гүйцэтгэл хангалтгүй байхад батлагдсан 200.0 сая төгрөгийг бүрэн олгосон байна.



Ингэснээр санхүүжилтийг бодит гүйцэтгэл, гэрээний нөхцөлтэй уялдуулан олгох зарчим алдагдаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн сахилга бат алдагдах, илүү болон урьдчилан олгогдсон хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах, улмаар ажлын чанар, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх, цаашид хяналт шалгалтаар зөрчил, хариуцлага үүсэх эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь гүйцэтгэлийн хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагаа хангалтгүй, санхүүжилт олголтыг бодит үр дүн, ажлын явцтай уялдуулахгүй хэрэгжүүлсэн, мөн дотоод хяналтын тогтолцоо сул байгаатай холбоотой байна.

Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтын дансаар дамжуулан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах үйл ажиллагаанд 1,111.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- ✓ Боловсролын / багш нарын нийгмийн баталгааг хангах/ 400.0 сая төгрөг
- ✓ Эрүүл мэндийн /эмч нар нарын нийгмийн баталгааг хангах/ 380.0 сая төгрөг
- ✓ Улс бүсийн тэмцээнд амжилттай оролцсон оюутны урамшуулал 17.0 сая төгрөг
- ✓ Засаг даргын нэрэмжит тэтгэлэг 17.0 сая төгрөг
- ✓ ЭЕШ-ын хэмжээст оноогоор аймгийн Засаг даргын тэтгэлэг 33.8 сая төгрөг
- ✓ Цэцэн-Уул сумын төрийн байгууллагуудыг засварлаж, тоног төхөөрөмжөөр хангах 22.6 сая төгрөг
- ✓ Архивын тоон төхөөрөмж худалдан авах 27.8 сая төгрөг
- ✓ УЦУОШТөвийн цаг уурын арга хэмжээнд 5.0 сая төгрөг
- ✓ Санмаргаз сумын халуун усны барилгын өргөтгөх 181.0 сая төгрөг
- ✓ Завханмандал сумын Төрийн байгууллагуудад хүүхдийн өрөө байгуулах 26.9 сая төгрөг

Данс хооронд гүйлгэн 279.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- ✓ Аймгийн 24 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах төсөл, арга хэмжээний 63.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олгож данс хооронд гүйлгэн зарцуулсан.
- ✓ Барьцаа хөрөнгийн данснаас 216.9 сая төгрөгийг Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгад засварын санхүүжилтэнд олгосон зэрэг зориулалтын бус зарцуулалтууд хийгдсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын дансаар төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлуудыг санхүүжүүлсэн нь төсвийн төлөвлөлт хангалтгүй хийгдсэн, зарцуулалтын ангилал болон зориулалт тодорхой бус байсантай, мөн дотоод хяналт, зөвшөөрөл олголт сул хэрэгжсэн, данс хоорондын шилжүүлэг болон барьцаа хөрөнгийн дансны зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байсантай холбоотой байна.

Ингэснээр төсвийн хөрөнгө зориулалтын бусаар зарцуулагдаж, санхүүгийн сахилга бат алдагдах, хөрөнгө оруулалтын үр ашиг буурах, тайлагналын үнэн зөв байдал алдагдах, төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт саатах зэрэг сөрөг үр дагавар үүссэн байна. Энэ нь төсвийн хөрөнгийн буруу зарцуулалт давтагдах, аудитын зөрчил нэмэгдэх, санхүүгийн хариуцлага тооцох боломж буурах, шийдвэр гаргалт болон санхүүгийн ил тод байдал алдагдах зэрэг ноцтой эрсдэлийг бий болгож байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дансаар дамжуулан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлуудыг санхүүжүүлсэн нь төсвийн төлөвлөлт, зарцуулалтын сахилга бат сул байгааг харуулж байна. Мөн данс хоорондын шилжүүлэг болон зориулалтын бус зарцуулалт хийгдсэн нь санхүүгийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй байгааг илтгэж байна.

Цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг бодит хэрэгцээ, батлагдсан төсөвтэй уялдуулан сайжруулах, зориулалтын бус зарцуулалтыг таслан зогсоох

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

шаардлагатай байна. Мөн данс хоорондын шилжүүлэг, санхүүжилт олголтод тавих дотоод хяналтыг чангатгах, шийдвэр гаргалтыг ил тод, баримтжуулалттай болгох, хариуцлагын тогтолцоог тодорхой болгож мөрдүүлэх нь зүйтэй. Ингэснээр төсвийн хөрөнгийн үр ашиг нэмэгдэж, санхүүгийн сахилга бат сайжрах нөхцөл бүрдэх юм.

Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн зарим хөрөнгийг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн аваагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн, гэрээний хугацаанд ашиглалтад хүлээн авсан 61 төсөл арга хэмжээг техникийн тодорхойлолт, ажлын даалгаварын дагуу хүлээн авсан эсэхд хяналт хэрэгжүүлэхэд дараах төсөл арга хэмжээнүүдийг техникийн тодорхойлолтод заасан шаарлагыг хангаагүй байхад хүлээн авсан байна.

- ✓ Хүүхэд хамгааллын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх автомашин нийлүүлэх 56.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ

Хүснэгт №9 Автомашины техникийн тодорхойлолтын харьцуулалт

Нэр	Техникийн тодорхойлолт	Нийлүүлэгдсэн автомашины үзүүлэлт
Дугуй	225/65 R18 шинэ өвлийн дугуй байна.	225/65 R16 хуучин өвлийн дугуй
Суудал	Үйлдвэрийн арьс	Даавуун
Хаалга	Бүх хаалга автоматаар сорж хаагддаг	Урд 2 хаалга сорж хаагдахгүй

Эх сурвалж: Аудитын ажлын баримт



Дээрх шаардлагуудыг хангахгүй байхад автомашиныг хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолт, гэрээний дагуу шаардлагад бүрэн нийцсэн байна гэж үзэн автомашиныг хүлээн авсан байна.

- ✓ Эрдэнэхайрхан, Яруу сумдад газар тарайлангийн усалгааны систем нийлүүлэх тус бүр 49.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод тусгасан дизель хөдөлгүүрийн усны насосыг ирүүлээгүй байна.

Хүснэгт №10 Дизель хөдөлгүүрийн техникийн тодорхойлолтын харьцуулалт

Техникийн тодорхойлолт	Нийлүүлэгдсэн автомашины үзүүлэлт
56 ба түүнээс дээш морины чадалтай байх	Хүчин чадал тодорхойгүй /бууруулсан/ Хөргөх радиотор байхгүй болсон Түлшний банк, яндан жижгэрсэн

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Нийлүүлсэн хөдөлгүүрийн зураг



Нийлүүлэхээр ирүүлсэн хөдөлгүүрийн зураг



Дээрх шаардлагуудыг хангаагүй байхад автомашиныг техникийн тодорхойлолт болон гэрээний шаардлагад бүрэн нийцсэн гэж үзэн хүлээн авсан байна.

Энэ нь гүйцэтгэлийн чанарын хяналт сул, хүлээн авах комиссын шалгалт хангалтгүй, техникийн тодорхойлолт болон ажлын даалгаврын шаардлагыг нарийвчлан шалгаж баталгаажуулаагүй “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.2¹⁹ дахь заалтай нийцээгүй байна.

Ингэснээр чанарын шаардлага хангаагүй хөрөнгө, ажил үйлчилгээг ашиглалтад оруулж, төсвийн хөрөнгийн үр ашиг буурах, ашиглалтын явцад нэмэлт засвар үйлчилгээний зардал гарах, байгууллагын хэрэгцээ, стандарт шаардлагад нийцээгүй хөрөнгө ашиглагдах нөхцөл бүрдэж байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөө буурах эрсдэлийг бий болгож байна.

Цаашид хүлээн авах комиссын үйл ажиллагааг сайжруулж, техник хяналтыг бодит гүйцэтгэлтэй тулган шалгах нарийвчилсан шалгах хуудас (checklist) болон стандарт журмыг мөрдүүлж ажиллуулах шаардлагатай байна. Мөн техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын шаардлагыг бүрэн хангаж байгаа эсэхийг

¹⁹ Санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх

баримтаар нотлон баталгаажуулсны дараа ашиглалтад хүлээн авдаг тогтолцоог хэрэгжүүлэх, хариуцлагын тогтолцоог тодорхой болгож зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгагдаагүй, мөн өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэж заасан бөгөөд аудитаар ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ✓ Улиастай сумын ХТҮА-ны 89.9 сая төгрөгийн Улиастай сумын Чигэстэй багт гэрэлтүүлэг, 180.4 сая төгрөгийн Чигэстэй, Жинст багийн гэрэлтүүлэг, 239.0 сая төгрөгийн Автогрейдер, Эрдэнэхайрхан сумын 189.9 сая төгрөгийн 15 ширхэг цамхагт гэрэлтүүлэг, 49.9 сая төгрөгийн газар тариалангийн усалгааны систем, Цагаанхайрхан сумын 179.8 сая төгрөгийн Ковш-50, 130.0 сая төгрөгийн ЭМТ-д нөхөн сэргээх физик эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмж, Яруу сумын 181.4 сая төгрөгийн газар тариалангийн иж бүрэн тоног төхөөрөмж, 49.9 сая төгрөгийн газар тариалангийн усалгааны систем, Ховд аймгийн ГИХГ-ын 159.0 сая төгрөгийн автомашин, Дөрвөлжин сумын 200.0 сая төгрөгийн ундны усны эх үүсвэрт ус цэвэршүүлэгч суурилуулах зэрэг 1,649.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.
- ✓ Амь-Ус ХХК-ын 67.0 сая төгрөгийн Богдын гол багийн ус түгээх №10, №18 дугаар байрыг цэвэр усны төв шугамд холбох, 49.9 сая Цагаанчулуут сумын сургуулийн барилгад засвар, 157.7 сая төгрөгийн Нөмрөг сумын спорт заалыг засварлах, 47.1 сая төгрөгийн Цэцэн-Уул сумын цэцэрлэгийн дотор сантехникийг засварлах, 89.5 сая төгрөгийн Цагдаагийн газрын гаржийн дээврийг засварлах, 94.0 сая төгрөгийн жавхлант цогцолбор сургуулийн спорт зааланд агч модон шал шинээр хийх, 1,076.7 сая төгрөгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгад засварлах, 339.4 сая төгрөгийн Отгон сумын соёлын төвийн хуучин барилгыг засварлах, 52.0 сая төгрөгийн Отгон сумын соёлын төвийг халаалтын шугамд холбох зэрэг 1,973.4 сая төгрөгийн хөрөнгийг капиталжуулалтад хамаарах их засварын ажлууд бүртгэлд тусгаагдаагүй байна

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 3,622.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7²⁰ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5

²⁰ Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах

дугаар зүйлийн 5.1²¹, 5.1.4²², 14 дүгээр зүйлийн 14.4²³, 14.4.2²⁴ дахь заалтуудыг зөрчиж, хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй тул холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нийт 12,665.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 7.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,914.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 заалт зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 9,743.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 7 заалт зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн бөгөөд шийдвэрийн хэрэгжилт 78.3 хувьтай байна.

Аймгийн Засаг даргад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх аудитаар өгсөн 3 заалт бүхий зөвлөмж, 2 заалт бүхий албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй байна. Үүнд: орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах төсөл, арга хэмжээг аймгийн бодлогын баримт бичгүүдтэй бүрэн уялдуулан төлөвлөх, иргэдийн саналыг авч эрэмбэлэх; хөрөнгө оруулалтаас бий болсон 1,418.9 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудын санхүүгийн тайланд бүрэн, үнэн зөв тусгуулах; мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд худалдан авсан боловч одоог хүртэл ашиглагдаагүй, ашиглалтад орох хугацаа тодорхойгүй орон нутгийн өмчид бүртгэлтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах арга хэмжээ авах зэрэг болно.

Төсөв захирагчид өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэт жижиглэн төлөвлөсөн, аудитаар илэрсэн зөрчлүүд давтан гарсан, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг бодлогын баримт бичигтэй уялдуулан оновчтой хэрэгжүүлээгүй, мөн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг данс бүртгэлд бүрэн, үнэн зөв тусгаагүй зэрэг зөрчлүүд давтан гарсаар байна.

Энэ нь өмнө аудитаар өгсөн шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, дотоод хяналт сул байгааг харуулж байгаа тул цаашид хэрэгжилтийг бүрэн хангуулж, төлөвлөлт, бүртгэл, хяналтыг сайжруулан зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

Аудитаар нийт 14,028.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж 7.7 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,250.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 19 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 770.8 сая төгрөгийн 12 заалт зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

---oOo---

²¹ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална

²² Үнэн зөв байх

²³ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ

²⁴ Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх төсөл арга хэмжээний 86.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 10.8 хувь нь гүйцэтгэл дутуу, 2.7 хувь нь Арцсуурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих төслийн хувьд тендерийг 4 удаа зарласан боловч шаардлага хангасан аж ахуйн нэгж санал ирүүлээгүй тул дараа онд шилжсэн байна. Харин Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийн засварын ажлын төсөлд тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан боловч гүйцэтгэгч байгууллага ажлыг хугацаанд нь эхлүүлээгүйгээс улмаас огт хэрэгжээгүй байна.
2. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид өөрийн сум, тойрогт чиглэсэн төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан нь тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлсэн, тооцоо судалгаатай ажлуудыг төлөвлөх боломжийг хязгаарласан байна.
3. Аймгийн ИТХ нь Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн барьсан төсвийг батлахдаа техник, эдийн засгийн үндэслэл хийгээгүй, зураг төсөвгүй, хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг оруулан баталсан байна.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тусдаа төсөвтэй байгууллагуудын хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж, түүний зорилго, мөн чанарыг алдагдуулж байна.
5. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт тодорхойгүй, үнэлгээний хороо байгуулах болон захиалагчаас хүсэлтийг хугацаа алдаж хүргүүлсэн зэргээс шалтгаалан нийт зохион байгуулсан худалдан авах ажиллагааны 31.3%-ийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулж дуусгаагүй байна.
6. Үнэлгээний хороод тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй 41 оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.
7. Үнэлгээний хорооны гишүүд, сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагч нарт тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийг хянан үзэх, үнэлэх зэрэг мэргэжил арга, зүйн зөвлөгөөгөөр хангаж, үүрэг хариуцлагыг идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.
8. Өмнөх аудитаар өгсөн албан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, худалдан авах ажиллагаанд гаргасан гомдлын шийдвэрийн мөрөөр хяналт тавиагүй, захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрт тооцох хариуцлага сул байна.
9. Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд нэгдсэн удирдамжаар дотоод аудит хийж хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авах зайлшгүй шаардлага үүссэн байна.

10. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн гэрээг бүрэн дүгнэж баталгаажуулаагүй байна.
11. Сумдад хэрэгжиж буй барилга байгууламж, их засварын ажлуудад Барилгын тухай хуульд заасны дагуу захиалагчийн болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлээгүй, мөн ажлын бодит гүйцэтгэлд үндэслэлгүйгээр санхүүжилтийг илүү олгосон байна.
12. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарим ажлыг техникийн тодорхойлолтод нийцүүлэн хүлээн аваагүй байна.
13. Их засвар, барилга байгууламжийн ажлын хүрээнд зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлэх, тухайлбал хяналтын төсөв боловсруулсан байгууллагатай зохиогчийн хяналтын гэрээг заавал байгуулж, хяналт тавиулах шаардлагатай байна.
14. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хууль тогтоомжийн дагуу захиалагчийн хяналт хэрэгжиж байгаа боловч гүйцэтгэгчийн гаргасан зөрчил, дутагдалд хариуцлага тооцох ажиллагаа хангалтгүй байгаагаас гэрээний хугацаа хэтрэх, улмаар төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.
15. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.
16. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж бүрэн ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээ нь хүүхдийн сурч, боловсрох болон иргэдийн ажиллаж, амьдрах орчинд эерэг нөлөө үзүүлж байна.
17. Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 78.3 хувьтай байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар уламжлах санал:

Сангийн яамнаас тендертэй холбоотой гомдлыг хянан үзэхдээ ТБОНӨХБАҮХАТХуулийн 16 дугаар зүйл санхүүгийн чадавхын шаардлага болох түргэн хөрвөн чадвартай хөрөнгийг нотлох харилцагч банкны тодорхойлолтод "... тендерт оролцож шалгарсан нөхцөлд ... төгрөгийн зээлийг олгох боломжтой" гэсэн заалтыг шаардлага хангасан, хангаагүй гэх зэрэг 2 өөр байдлаар хянаж байгаа нь аймгийн Худалдан авах ажиллагааны газар болон үнэлгээний хороодод ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Иймд Сангийн яамнаас гаргаж буй гомдол хянасан шийдвэрүүд нь хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлэх саналтай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа төсөвлөлтийн шаардлага хангасан арга хэмжээг баталж байх;
2. Эрдэнэхайрхан суманд илүүдэлтэй байгаа 6 ширхэг цамхагт гэрэлтүүлгийг бодит хэрэгцээ, ачаалал, хүн амын нягтаршил, гэрэлтүүлгийн хүртээмжид нийцүүлэн нэн шаардлагатай бусад сум, суурин газарт холбогдох хууль, журмын дагуу шилжүүлэн ашиглахын зэрэгцээ цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хэрэгцээний судалгаа, техник-эдийн засгийн үндэслэл, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бодитой, үндэслэлтэйгээр тооцож, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үр ашгийг дээшлүүлэх, мөн шийдвэр гаргах түвшинд давхардал, илүүдэл үүсэх эрсдэлийг урьдчилан тооцож байх;
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд нэгдсэн удирдамжаар дотоод аудит хийж хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авч үр дүнг тайлагнах;
4. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, холбогдох журмын хүрээнд яаралтай зохион байгуулж, төлөвлөгөөт хугацаанд нь багтаан бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байх;
5. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэл, баримт бичгийн бүрдэл, холбогдох албан тушаалтнуудын хяналт, баталгаажуулалтыг бүрэн хангуулсны үндсэн дээр олгож байх;
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, данс хооронд гүйлгэн зарцуулахгүй байх;
7. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хүлээн авахдаа техникийн тодорхойлолт, зураг төсөв, холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангуулж байх, шаардлага хангаагүй ажлыг хүлээн авахгүй байх.

Сумын Засаг дарга нар-т

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах санхүү, техникийн болон туршлагын шаардлагыг тодорхой тусгаж байх;
2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төлөвлөгөөнд тусгасан цаг хугацааг мөрдөн ажиллах, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;
3. Үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулах болон тендерийг хянаж, үнэлэхдээ бүх гишүүдийн оролцоог хангах, үнэлгээг маягтын дагуу хийх, хурлын тэмдэглэлийг журмын дагуу бүрэн гүйцэд үнэн зөв хөтлөх

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар-т

1. Түншлэл, туслан гүйцэтгэгчийн мэдээллийг дүгнэлт, зөвлөмж, гэрээнд бүрэн тусгаж байх.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар-т

1. Сумдад хэрэгжүүлж байгаа барилга байгууламж, их засварын ажлын мэдээллийн самбарыг стандартын шаардлагын дагуу бүрэн хийж байршуулах, Барилгын тухай хуульд заасны дагуу захиалагчийн болон зохиогчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлэн, захиалагч болон хяналт хэрэгжүүлэгч байгууллагын хяналт, хариуцлагыг сайжруулж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу гаргаж, мөн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Байгууллагаас ирсэн санал:



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Хатанбаатар Магсаржавын 1-116 тоот
Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
Цахим шуудан: info@zavkhan.gov.mn
Цахим хуудас: Zavkhan.gov.mn


2026.05.06 № 06/482
танай _____ -ны № _____ Т


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Орон төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт нийцлийн аудитын тайлантай танилцан холбогдох саналаа хавсралтаар хүргүүллээ.

Бидний хүсэлтийг хүлээн авч тайланд тусгаж өгнө үү.

Хавсралт 3 хуудастай.

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.АЗЖАРГАЛ



Doc toot a5

8126170535

**“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ АУДИТЫН
ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ**

БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 28.4 ХУВИЙГ АЙМГИЙН 2021-2025 ОНЫ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн боловч, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд үндэслэн төлөвлөөгүй байна.

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж уялдсан байхаар зохицуулалт хийгдсэн байх тул 5 жилийн үндсэн чиглэлд тухайн ажлуудыг үр дүнгээр төлөвлөсөн бөгөөд үг үсгээр нэг бүрчлэн тусгагдаагүй ч ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт агуулгаар тусгагдсан байна. Иймд тайлангийн энэ хэсэгт өөрчлөлт оруулж бодлогын баримт бичигтэй уялдаагүй 21 төсөл арга хэмжээний 2,5 тэрбум төгрөгийн зөрчлийг хасуулах саналтай.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүд нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхэд ажиглалт хийхэд дараах төсөл арга хэмжээнүүдийг нэн тэргүүний асуудал гэх үндэслэлгүй байна. Үүнд:

- ✓ Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг тоног төхөөрөмжөөр хангах,
- ✓ Цагаанхайрхан сумын ЭМТ-д нөхөн сэргээх физик эмчилгээ, оношилгооны төв байгуулах,
- ✓ Аймгийн 24 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах,
- ✓ Яруу суманд газар тариалангийн усалгааны систем авах,
- ✓ Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг дэмжиж тоног төхөөрөмж авах,
- ✓ Эрдэнэхайрхан суманд газар тариалангийн усалгааны систем авах,
- ✓ Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйлчилгээний автомашин авах,
- ✓ Сум дундын Прокурорын газарт тоног төхөөрөмж авах,
- ✓ Аймгийн Прокурорын газарт тоног төхөөрөмж авах,
- ✓ Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газарт автомашин авах,
- ✓ Идэр сумын ЕБС-ийн гадна хайс, тохижилт хийх зэрэг байна.
- Дээрх төсөл арга хэмжээнүүд төрийн үйлчилгээг тасралтгүй явуулахад нэн шаардлагатай төсөл арга хэмжээ байх бөгөөд зарим салбарын хууль, Салбарын сайдтай байгуулсан гэрээнд аймгийн ЗД үүрэг

хүлээсэн арга хэмжээ, мөн 3Д-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан, газар тариаланг нэмэгдүүлэх нэн шаардлагатай төсөл арга хэмжээнүүд тул тайлангийн хэсгээс хасуулах саналтай.

3.1 Хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй, мөн зарим тохиолдолд санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

- 2025 оны төсвийн орлого тасарч Сангийн яамнаас зардлын эрх нээгээгүйтэй холбоотойгоор зарим төсөл арга хэмжээ удаашрах, санхүүжилт хийгдэхгүй байх нөхцөл бүрдсэн, Санхүүжилтийг олгохдоо хэрэгжих боломжийг олгох, төсөл арга хэмжээг нэн яаралтай чанартай гүйцэтгүүлэх тал дээр анхаарч олгож байна.

Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтын дансаар дамжуулан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах үйл ажиллагаанд 903.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН 28

- ✓ Боловсролын / багш нарын нийгмийн баталгааг хангах/ 400.0 сая төгрөг
- ✓ Эрүүл мэндийн /эмч нар нарын нийгмийн баталгааг хангах/ 380.0 сая төгрөг
- ✓ Улс бүсийн тэмцээнд амжилттай оролцсон оюутны урамшуулал 17.0 сая төгрөг
- ✓ Засаг даргын нэрэмжит тэтгэлэг 17.0 сая төгрөг
- ✓ ЭЕШ-ын хэмжээст оноогоор аймгийн Засаг даргын тэтгэлэг 33.8 сая төгрөг
- ✓ Цэцэн-Уул сумын төрийн байгууллагуудыг засварлаж, тоног төхөөрөмжөөр хангах 22.6 сая төгрөг
- ✓ Архивын тоон төхөөрөмж худалдан авах 27.8 сая төгрөг
- ✓ УЦУОШТөвийн цаг уурын арга хэмжээнд 5.0 сая төгрөг зарцуулсан.

- Дээрх зардлууд Засаг даргын ерөнхий дансанд төлөвлөсөн мөн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ажил бөгөөд төсвийн орлого тасарснаас үүдэн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс зарцуулсан байна.

Данс хооронд гүйлгэн 487.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- ✓ ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хөрөнгө оруулалтын данснаас 207.9 сая төгрөгийг данс хооронд гүйлгэн зарцуулсан.
- ✓ Аймгийн 24 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах төсөл, арга хэмжээний 63.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олгож данс хооронд гүйлгэн зарцуулсан.
- ✓ Барьцаа хөрөнгийн данснаас 216.9 сая төгрөгийг санхүүжилтээр олгосон зэрэг зориулалтын бус зарцуулалтууд хийгдсэн байна.

- Дээрх данс хооронд гүйлгэн зарцуулсан төсөл арга хэмжээ төсвийн орлого тасарсантай холбоотойгоор зайлшгүй цаг хугацааны хувьд хэрэгжүүлэх ажил байсан тул хооронд гүйлгэн зарцуулсан бөгөөд 2026 оны төсвийн төлөвлөлтөд залруулахаар төлөвлөсөн. Иймд дээрх дүнг алдаа зөрчлийн нэгтгэлээс хасуулах саналтай.

3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгагдаагүй, мөн өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

- Орон нутгийн өмчийн газраас өмч бүртгэлийг сайжруулах зорилгоор журам боловсруулан аймгийн ИТХ-ын 1-р улирлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар хүлээгдэж байна. Дээрх журам батлагдсан тохиолдолд өмч хөрөнгийг тухай бүр нягтлан бодох бүртгэлд тусгаг өмчид хяналт тавих нөхцөл бүрдэнэ.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Төрийн аудитын газраас шийдвэрлэсэн байдал:

д/д	Ирүүлсэн санал тайлбар	Төрийн аудитын газрын шийдвэр
1.	1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн боловч, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд үндэслэн төлөвлөөгүй байна. Тайлбар: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь аймгийн 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж уялдсан байхаар зохицуулалт хийгдсэн байх тул 5 жилийн үндсэн чиглэлд тухайн ажлуудыг үр дүнгээр төлөвлөсөн бөгөөд үг үсгээр нэг бүрчлэн тусгагдаагүй ч ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт агуулгаар тусгагдсан байна. Иймд тайлангийн энэ хэсэгт өөрчлөлт оруулж бодлогын баримт бичигтэй уялдаагүй 21 төсөл арга хэмжээний 2.5 тэрбум төгрөгийн зөрчлийг хасуулах саналтай.	Уг зөрчил нь аудитын нотлох баримтаар баталгаажиж, зөрчлийн бүртгэлд мөнгөн дүнгүйгээр тусгагдсан тул холбогдох саналыг хүлээн авах боломжгүй.
2.	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүд нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэхэд ажиглалт хийхэд дараах төсөл арга хэмжээнүүдийг нэн тэргүүний асуудал гэх үндэслэлгүй байна. Үүнд: - Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг тоног төхөөрөмжөөр хангах, - Цагаанхайрхан сумын ЭМТ-д нөхөн сэргээх физик эмчилгээ, оношилгооны төв байгуулах, - Аймгийн 24 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, - Яруу суманд газар тариалангийн усалгааны систем авах, Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааг дэмжиж тоног төхөөрөмж авах, - Эрдэнэхайрхан суманд газар тариалангийн усалгааны систем авах, - Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйлчилгээний автомашин авах, - Сум дундын Прокурорын газарт тоног төхөөрөмж авах, - Аймгийн Прокурорын газарт тоног төхөөрөмж авах, - Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газарт автомашин авах,	Уг асуудлыг цаашид анхааруулах зорилгоор аудитын тайланд тусгаж, зөрчлийн бүртгэлд бүртгээгүй тул холбогдох саналыг хүлээн авах боломжгүй байна.

	- Идэр сумын ЕБС-ийн гадна хайс, тохижилт хийх зэрэг байна. Тайлбар: Дээрх төсөл арга хэмжээнүүд төрийн үйлчилгээг тасралтгүй явуулахад нэн шаардлагатай төсөл арга хэмжээ байх бөгөөд зарим салбарын хууль, Салбарын сайдтай байгуулсан гэрээнд аймгийн ЗД үүрэг хүлээсэн арга хэмжээ, мөн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан, газар тариаланг нэмэгдүүлэх нэн шаардлагатай төсөл арга хэмжээнүүд тул тайлангийн хэсгээс хасуулах саналтай	
3.	3.1 Хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй, мөн зарим тохиолдолд санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна. Тайлбар: 2025 оны төсвийн орлого тасарч Сангийн яамнаас зардлын эрх нээгээгүйтэй холбоотойгоор зарим төсөл арга хэмжээ удаашрах, санхүүжилт хийгдэхгүй байх нөхцөл бүрдсэн, Санхүүжилтийг олгохдоо хэрэгжих боломжийг олгох, төсөл арга хэмжээг нэн яаралтай чанартай гүйцэтгүүлэх тал дээр анхаарч олгож байна.	Төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй, мөн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон тул уг саналыг хүлээн авах боломжгүй байна.
4.	Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтын дансаар дамжуулан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах үйл ажиллагаанд 903.2 сая төгрөгийг зарцуулсан байна. - Боловсролын / багш нарын нийгмийн баталгааг хангах/ 400.0 сая төгрөг - Эрүүл мэндийн /эмч нар нарын нийгмийн баталгааг хангах/ 380.0 сая төгрөг - Улс бүсийн тэмцээнд амжилттай оролцсон оюутны урамшуулал 17.0 сая - Засаг даргын нэрэмжит тэтгэлэг 17.0 сая төгрөг - ЭЕШ-ын хэмжээст оноогоор аймгийн Засаг даргын тэтгэлэг 33.8 сая төгрөг - Цэцэн-Уул сумын төрийн байгууллагуудыг засварлаж, тоног төхөөрөмжөөр хангах 22.6 сая төгрөг - Архивын тосон төхөөрөмж худалдан авах 27.8 сая төгрөг - УЦУОШ Төвийн цаг уурын арга хэмжээнд 5.0 сая төгрөг зарцуулсан. Тайлбар: Дээрх зардлууд Засаг даргын ерөнхий дансанд төлөвлөсөн мөн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ажил бөгөөд төсвийн орлого тасарснаа үүдэн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс зарцуулсан байна.	Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг данс хооронд гүйлгэн зарцуулсан зөрчлийг тухайн тайлант онд залруулах боломжтой байсан тул холбогдох саналыг хүлээн авах боломжгүй байна.

5.	Данс хооронд гүйлгэн 487.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: - ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хөрөнгө оруулалтын данснаас 207.9 сая төгрөгийг данс хооронд гүйлгэн зарцуулсан. - Аймгийн 24 сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах төсөл, арга хэмжээний 63.0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс олгож данс хооронд гүйлгэн зарцуулсан. - Барьцаа хөрөнгийн данснаас 216.9 сая төгрөгийг санхүүжилтээр олгосон зэрэг зориулалтын бус зарцуулалтууд хийгдсэн байна. Тайлбар: Дээрх данс хооронд гүйлгэн зарцуулсан төсөл арга хэмжээ төсвийн орлого асарсантай холбоотойгоор зайлшгүй цаг хугацааны хувьд хэрэгжүүлэх ажил байсан тул хооронд гүйлгэн зарцуулсан бөгөөд 2026 оны төсвийн төлөвлөлтөд залруулахаар төлөвлөсөн. Иймд дээрх дүнг алдаа зөрчлийн нэгтгэлээс хасуулах саналтай.	Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг данс хооронд гүйлгэн зарцуулсан зөрчлийг тухайн тайлант онд залруулах боломжтой байсан тул холбогдох саналыг хүлээн авах боломжгүй байна.
	3.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгагдаагүй, мөн өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна. Тайлбар: Орон нутгийн өмчийн газраас өмч бүртгэлийг сайжруулах зорилгоор журам боловсруулан аймгийн ИТХ-ын 1-р улирлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар хүлээгдэж байна. Дээрх журам батлагдсан тохиолдолд өмч хөрөнгийг тухай бүр нягтлан бодох бүртгэлд тусгаг өмчид хяналт тавих нөхцөл бүрдэнэ.	Тайлан болон зөрчилд холбогдуулан хүлээн авах үндэслэлтэй тайлбар ирүүлээгүй тул тайланг хэвээр үлдээхээр шийдлээ.



**ЗАВХАН АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 1 дүгээр баг,

Улиастай сум, Завхан аймаг, 81090

Утас: (976) 7046-2369

Цахим шуудан: zavkhanhaa@gmail.com

2026.05.07 № 189
танай 2026.05.05 -ны № 289 Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайлангийн төсөлд санал хүргүүлэв.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА  Х.ОНОЛБААТАР

8126050048



Банкны зээлийн тодорхойлолтыг үнэлсэн байдал нь албан шаардлага хүргүүлэх нөхцөл болохыг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Тайлбар:

1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана гэж ТШЗ-ны холбогдох хэсэгт тусгагдсан. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх зүйлд Харилцагч банкны мэдэгдэл, Иймд тухайн заалт нь хуулийн хүрээнд Тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгагдсан.
2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." гэж заасан. Тендерт оролцогчдыг Өрсөлдөх тэгш боломжоор хангаж ажилласан.
3. Шаардлагад нийцсэн гэж үнэлсэн банкны зээлийн тодорхойлолтуудад Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал зааврын 6.2-т заасан "зээл олгох асуудлыг судлан үзэх" гэсэн агуулга тусгагдаагүй.
4. Сангийн яамны Гомдол хянасан тухай бичигт Тендерт оролцогчийн банкны зээлийн тодорхойлолтод "тендерт оролцож шалгарсан нөхцөлд мөнгөн дүн бүхий зээлийг олгох боломжтой" гэж дурдсан байхад шаардлагад нийцэхгүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна. гэсэн дүгнэлт, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах тухай албан бичиг ирүүлсэн.
5. Цаашид санхүүгийн чадавхыг хангах банкны зээлийн тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хэрхэн тусгах, үнэлэх асуудалд оновчтой шийдэл олох тал дээр анхаарч ажиллах.

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй гэсэн дүгнэлтэд албан шаардлага хүргүүлэх нөхцөл болохыг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Тайлбар:

1. 2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмж 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр ирсэн. 2025 онд нийт 63 тендер шалгаруулалт зарласан, түүнээс тухайн өдрийн байдлаар 47 тендер шалгаруулалтыг 66 удаа зарлаж, үр дүнг нийтэлсэн байсан.
2. Тухайн онд аудитаас ирсэн зөвлөмжийн дагуу:
 - Авч хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүлсэн
 - 7 сумд очиж сургалт зохион байгуулан зөвлөн тусалж ажилласан, сумдад удаа дараа албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.
 - Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Х.Онолбаатарт аймгийн Засаг даргын захирамжаар сануулах арга хэмжээ авсан.

—o0o—

Төрийн аудитын газраас шийдвэрлэсэн байдал:

д/д	Ирүүлсэн санал тайлбар	Төрийн аудитын газрын шийдвэр
	Банкны зээлийн тодорхойлолтыг үнэлсэн байдал нь албан шаардлага хүргүүлэх нөхцөл болохыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Тайлбар: 1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана гэж ТШЗ-ны холбогдох хэсэгт тусгагдсан. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх зүйлд Харилцагч банкны мэдэгдэл, Иймд тухайн заалт нь хуулийн хүрээнд Тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгагдсан. 2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж заасан. Тендерт оролцогчдыг Өрсөлдөх тэгш боломжоор хангаж ажилласан. 3. Шаардлагад нийцсэн гэж үнэлсэн банкны зээлийн тодорхойлолтуудад Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал зааврын 6.2-т заасан “зээл олгох асуудлыг судлан үзэх” гэсэн агуулга тусгагдаагүй. 4. Сангийн яамны Гомдол хянасан тухай бичигт Тендерт оролцогчийн банкны зээлийн тодорхойлолтод “тендерт оролцож шалгарсан нөхцөлд мөнгөн дүн бүхий зээлийг олгох боломжтой” гэж дурдсан байхад шаардлагад нийцэхгүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна. гэсэн дүгнэлт, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах тухай албан бичиг ирүүлсэн. 5. Цаашид санхүүгийн чадавхыг хангах банкны зээлийн тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хэрхэн тусгах, үнэлэх асуудалд оновчтой шийдэл олох тал дээр анхаарч ажиллах.	Саналыг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Сангийн яамнаас харилцагч банкны тодорхойлолтод “... тендерт оролцож шалгарсан нөхцөлд ... төгрөгийн зээлийг олгох боломжтой” гэсэн заалтыг шаардлага хангасан, хангаагүй гэх зэрэг 2 өөр байдлаар хянаж байгаа нь аймгийн Худалдан авах ажиллагааны газар болон үнэлгээний хороодод ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байгаа асуудлыг Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар хүргүүлэв.

	Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй гэсэн дүгнэлтэд албан шаардлага хүргүүлэх нөхцөл болохыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Тайлбар: 1. 2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмж 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр ирсэн. 2025 онд нийт 63 тендер шалгаруулалт зарласан, түүнээс тухайн өдрийн байдлаар 47 тендер шалгаруулалтыг 66 удаа зарлаж, үр дүнг нийтэлсэн байсан. 2. Тухайн онд аудитаас ирсэн зөвлөмжийн дагуу: • Авч хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүлсэн • 7 сумд очиж сургалт зохион байгуулан зөвлөн тусалж ажилласан, сумдад удаа дараа албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн. • Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга Х.Онолбаатарт аймгийн Засаг даргын захирамжаар сануулах арга хэмжээ авсан.	Саналыг хүлээн зөвшөөрөх боломжгүй.
--	---	--



**ЗАВХАН АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Улиастай сум, Завхан аймаг, 81090
Утас/Факс: 7046-26-20
Цахиаг буудал: zavkhan@gazar.gov.mn

2026. 05. 07 № 168
танай 2026. 05. 05 -ны 287 т

Хариу хүргүүлэх тухай

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга байгууламжийн угсралтын ажилд танай байгууллагаас хийсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн нийцлийн аудиттай танилцлаа.

2025 онд Улиастай Сумын Засаг даргатай техник хяналтын гэрээ байгуулан ажилласан ба бусад сумдад удаа дараа хүсэлт хүргүүлсэн боловч техник хяналтын гэрээ хийгдээгүй болно.

Мөн Улсын төсөв, гадаадын зээл тусламжаар хийгдэж байгаа төсөл арга хэмжээнд MNS7023:2023 стандартын дагуу мэдээллийн самбарыг байршуулсан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Иймд танай байгууллагаас өгсөн зөвлөмжийг 2026 онд хэрэгжүүлэн ажиллах тул зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна.

MNS7023:2023 стандартын дагуу мэдээллийн самбар байршуулсан ажлын тайланг хүргүүлж байна.

Хавсралт. 8. хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАЛЖИННЯМ

812603083